|---------------------------|------------------|------------------|-----------------|
| Бусад хангамжийн материал | 17,181.3 | 11,275.6 | -5,905.7 |
| Дүн | 245,117.5 | 311,599.2 | 66,481.7 |

Эх сурвалж: Баацагаан сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 311,599.2 мянган төгрөг болж өмнөх оноос 66,481.7 мянган төгрөгөөр өссөн нь ИТХ-ын хөрөнгө 976.3 мянга, ЗДТГ-ын хөрөнгө 6,406.3 мянга, Соёлын төвийн хөрөнгө 2,265.5 мянга, Сургуулийн хөрөнгө 17,509.8 мянга, Цэцэрлэгийн хөрөнгө 5,458.4 мянга, ОНХС-ийн хөрөнгө 46,272.0 мянга нийт 78,888.3 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Харин сумын ЭМТ-ийн бараа материалын данс өмнөх оноос 12,406.5 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр эм боох материал 115,001.5 мянга, бичиг хэргийн материал 2,963.3 мянга, аж ахуйн материал 14,585.5 мянга, шатахуун 18,713.6 мянган төгрөг, хүнсний материал 13,447.4 мянган төгрөг, бусад хангамжийн материал 6,587.9 мянга, нийт 148,890.6 мянган төгрөгөөр худалдан авч 162,486.6 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.

үзүүлэлттэй байна

Хүснэгт № 5. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|-----------------|------------------|------------------|------------------------|-----------------|
| ИТХ | 3,332.6 | 4,308.9 | 976.3 | 1.4 |
| ЗДТГ | 27,322.8 | 33,729.1 | 6,406.3 | 10.8 |
| Соёл | 19,867.1 | 22,132.6 | 2,265.5 | 7.1 |
| ЭМТ | 82,677.9 | 70,271.3 | -12,406.6 | 22.6 |
| ОНХС | 36,184.9 | 82,456.9 | 46,272.0 | 26.5 |
| ЕБС | 56,006.5 | 73,516.3 | 17,509.8 | 23.6 |
| Цэцэрлэг | 19,725.7 | 25,184.1 | 5,458.4 | 8.1 |
| НИЙТ ДҮН | 245,117.5 | 311,599.2 | 66,481.7 | 100.0 |

Эх сурвалж: Баацагаан сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт 509,933.3 мянган төгрөгийн бараа материал нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 422,877.7 мянга, шилжүүлэн авсан 63,589.6 мянга, аймгийн ЭМГ-аас олгосон 22,468.8 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, үнэ төлбөргүй хүлээн авсан 997.3 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авч бүртгэсэнтэй холбоотой бөгөөд нийт 443,925.0 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан байна.

Хүснэгт № 6. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

| Нэмэгдсэн | 509,933.3 | Хасагдсан | 443,925.0 |
|------------------|-----------|-----------------------|-----------|
| Худалдан авсан | 422,877.7 | Худалдсан, зарцуулсан | 335,565.3 |
| Хандиваар | 0.0 | шилжүүлсэн | 98,784.2 |
| Шилжүүлсэн авсан | 63,589.6 | | 98,784.2 |
| бусад | 23,466.0 | бусад | 9,575.5 |

Эх сурвалж: Баацагаан сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 6,887,293.0 мянга, эцсийн үлдэгдэл 7,316,247.2 мянган төгрөг болж 428,954.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|-------------------------------|----------------|-----------------|------------------------|-----------------|
| БИЕТ ХӨРӨНГӨ | 6,754,649.8 | 7,183,604.0 | 428,954.2 | 98.2 |
| Барилга байгууламж, орон сууц | 5,409,204.7 | 5,725,298.20 | 316,093.5 | 78.3 |

Аудитын код: БНА-2021/13/СТА-ТТЗ

Баацагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | |
|----------------------------|--------------------|--------------------|------------------|--------------|
| Тээврийн хэрэгсэл | 265,280.7 | 265,280.70 | 0.0 | 3.6 |
| Машин тоног төхөөрөмж | 571,997.6 | 655,436.40 | 83,438.8 | 9.0 |
| Тавилга эд хогшил | 293,797.4 | 326,548.20 | 32,750.8 | 4.5 |
| Номын фонд | 50,057.6 | 31,928.70 | -18,128.9 | 0.4 |
| Түүх соёлын дурсгалт зүйлс | 1,306.7 | 1,306.70 | 0.0 | 0.0 |
| Бусад үндсэн хөрөнгө | 163,005.1 | 177,805.10 | 14,800.0 | 2.4 |
| БИЕТ БУС ХӨРӨНГӨ | 132,643.2 | 132,643.2 | 0.0 | 1.8 |
| Программ хангамж | 9,217.2 | 9,217.20 | 0.0 | 0.1 |
| Бусад биет бус хөрөнгө | 123,426.0 | 123,426.00 | 0.0 | 1.7 |
| НИЙТ ДҮН | 6,887,293.0 | 7,316,247.2 | 428,954.2 | 100.0 |

Эх сурвалж: Баацагаан сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нэмэгдсэн 428,954.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нь Засаг даргын Тамгын газар 124,990.2 мянга, Сургууль 268,480.1 мянга, , Соёлын төв 397.0 мянга, ЭМТөв 41,351.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө өмнөх оноос нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|-----------------|--------------------|--------------------|---------------------------|--------------------|
| ИТХ | 16,849.0 | 16,849.0 | 0.0 | 0.2 |
| ЗДТГ | 1,804,035.2 | 1,929,025.4 | 124,990.2 | 26.4 |
| Соёл | 1,163,264.1 | 1,163,661.1 | 397.0 | 15.9 |
| ЭМТ | 1,367,902.6 | 1,409,253.6 | 41,351.0 | 19.3 |
| ЕБС | 1,749,304.6 | 2,017,784.7 | 268,480.1 | 27.6 |
| Цэцэрлэг | 785,937.5 | 779,673.4 | -6,264.1 | 10.7 |
| НИЙТ ДҮН | 6,887,293.0 | 7,316,247.2 | 428,954.2 | 100.0 |

Эх сурвалж: Баацагаан сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт 485,362.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 71,734.8 мянга, шилжүүлэн авсан 6,450.9 мянга, сумын ЭМТ-д аймгийн ЭМГ-аас үнэ төлбөргүй олгосон 33,800.9 мянга, Залуучуудын холбооноос олгосон 1,950.0 мянга, Сумын ЗДТГ-аас 3,600.0 мянга, нийт 39,350.9 төгрөгийн тоног төхөөрөмж, ОНХС-аас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 104,619.4 мянга, бусад байгууллагаас шилжүүлэн авсан 263,206.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авч бүртгэсэнтэй холбоотой байна.


Хүснэгт № 9. Үндсэн хөрөнгийн орлого зарлага /мянган төгрөг/

| | | | |
|-----------------|------------------|------------|-----------------|
| Нэмэгдсэн | 485,362.3 | Хасагдсан | 56,408.1 |
| Худалдан авсан | 71,734.8 | Худалдсан | |
| Хандиваар | 39,351.0 | Акталсан | 56,408.1 |
| Шилжүүлэн авсан | 6,450.9 | Шилжүүлсэн | |
| бусад | 367,825.6 | Бусад | |

Эх сурвалж: Баацагаан сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн зарлага 56,408.1 мянган төгрөг байгаа нь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021.12.28-ны өдрийн "Хөрөнгө актлах тухай" 156 дугаар тогтоолоор Цэцэрлэгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 18,367.5 мянга, Сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 18,420.9 мянга, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2008 оны 102 дугаар тогтоолоор Засаг даргын Тамгын газрын хөрөнгөд бүртгэлтэй "Баянхонгор-Эрчим" ЦТХХК-д шилжүүлсэн боловч хасагдаагүй байсныг өмнөх оны аудитаар зөвлөмж өгсний дагуу

Аудитын код: БНА-2021/13/СТА-ТТЗ



19,619.7 мянган төгрөгийн өртөг бүхий моторыг данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

3.5.5 Өр төлбөр

Өр төлбөр дансны эхний үлдэгдэл 9,480.3 мянга, эцсийн үлдэгдэл 21,053.6 мянган төгрөг болж 10,075.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|----------------------------------|----------------|-----------------|------------------------|-----------------|
| БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН | 9,480.3 | 21,053.6 | 10,075.8 | 100.0 |
| Ажилчидтай холбогдсон өглөг | 433.3 | 28.9 | (404.4) | 0.1 |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | 7,303.9 | 19,470.2 | 12,166.3 | 92.5 |
| Байгууллагад төлөх өглөг | 1,743.1 | 57.0 | (1,686.1) | 0.3 |
| Хувь хүмүүст өгөх өглөг | | 1,497.5 | 1,497.5 | 7.1 |
| Дүн | 9,480.3 | 21,053.6 | 10,075.8 | 100.0 |

Эх сурвалж: "Баацагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан"

Тус сумын нийт өр төлбөрийн 0.6 хувийг ЗДТГ, 99,1 хувийг ЭМТ, 0.1 хувийг Цэцэрлэг, 0.3 хувийг Сургуулийн өр төлбөр эзэлж байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 6,274,862.3 мянга, эцсийн үлдэгдэл 6,719,390.0 мянган төгрөг болж, 444,527.7 мянган төгрөгөөр өссөн нь хуримтлагдсан үр дүн 716,291.2 мянган төгрөгөөр өсч, үндсэн хөрөнгө акталснаас хөрөнгийн дахин үнэлгээний зардал 271,763.5 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт № 12. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өссөн+ Буурсан - | Дүнд эзлэх хувь |
|---|--------------------|--------------------|------------------|-----------------|
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,309,675.6 | 2,309,675.6 | - | 34.4 |
| Өмч: - төрийн | 2,309,675.6 | 2,309,675.6 | - | 34.4 |
| Хуримтлагдсан үр дүн | 1,440,123.4 | 2,156,414.6 | 716,291.2 | 32.1 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,525,063.3 | 2,253,299.8 | (271,763.5) | 33.5 |
| Дүн | 6,274,862.3 | 6,719,390.0 | 444,527.7 | 100.0 |

Эх сурвалж: Баацагаан сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.7 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2020.12.18-ны өдрийн "Баянхонгор аймгийн Баацагаан сумын 2021 оны төсөв батлах тухай" Хуралдааны 2/17 дугаартай тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 61,100.0 мянга, хүү торгуулийн орлогыг 11,000.0 мянга, нийт 72,100.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|-------------------|------------|-----------|---------|-------|
| 1.Татварын орлого | 61,100.0 | 68,941.5 | 7,841.5 | 112.8 |

Аудитын код: БНА-2021/13/СТА-ТТЗ

| | | | | |
|---|-----------------|-----------------|----------------|--------------|
| ИОТХ | 10,000.0 | 14,473.0 | 4,473.0 | 144.7 |
| Бууны татвар | 1,200.0 | 1,294.0 | 94.0 | 107.8 |
| Улсын тэмдэгтийн хураамж | 1,500.0 | 1,170.3 | (329.7) | 78.0 |
| Хадгаламжийн хүүгийн орлого | 37,100.0 | 37,520.9 | 420.9 | 101.1 |
| Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсаны орлого | 3,000.0 | 9,295.6 | 6,295.6 | 309.9 |
| Газрын төлбөр | 1,300.0 | 890.2 | (409.8) | 68.5 |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 6,000.0 | 3,672.5 | (2,327.5) | 61.2 |
| Түгээмэл тархацтай АМАТ | 1,000.0 | 625.0 | (375.0) | 62.5 |
| 2.Татварын бус орлого | 11,000.0 | 10,620.0 | (380.0) | 96.5 |
| 2.1.Хүү торгуулийн орлого | 11,000.0 | 10,620.0 | (380.0) | 96.5 |
| Нийт дүн | 72,100.0 | 79,561.5 | 7,461.5 | 209.4 |

Эх сурвалж: Баацагаан сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 7,461.5 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл иргэний орлого тодорхойлох хуудсаар тодорхойлсон татварын орлого 4,473.0 мянга, бууны татвар 94.0 мянга, хадгаламжийн хүүгийн орлого 420.9 мянга, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлого 6,295.6 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

Харин улсын тэмдэгтийн хураамж 22.0, хувь буюу 329.7 мянга, газрын төлбөр 31.5 хувь буюу 409.8 мянга, хог хаягдлын үйлчилгээний хураамж 38.8 хувь буюу 2,327.5 мянга, түгээмэл тархацтай АМАТ 37.5 хувь буюу 375.0 мянга, хүү торгуулийн орлого 3.5 хувь буюу 380.0 мянган төгрөгөөр орлого тус тус тасарсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогод Засаг даргын Тамгын газар 2000.0 мянга, Соёлын төв 2,494.4 мянга, нийт 4,494.4 мянган төгрөгийн орлогыг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 836.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж орлогын төлөвлөгөө 81.4 хувиар буюу 3,658.4 мянган төгрөгөөр тасарсан байна.

Сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн төлөлтөөр тайлант онд 63,500.0 мянган төгрөгийг оруулахаар баталснаас 81,727.8 мянган төгрөгийн орлогыг оруулсан байна.

3.5.8 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71702, 71801, 71802, 71806, 72101 гэсэн 8 хөтөлбөрт 2,573,509.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,331,956.2 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 2,191,348.3 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан бол 140,607.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн СТСХ-ээс авсан судалгаагаар тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 8 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн ба Эрүүл мэндийн системийн дээд байгууллага нь нэг хүнд ноогдох хувьсах зардлын нормативыг баримтлан тухайн сумын хүн амын тоотой харьцуулж төсвийг төлөвлөсөн ба Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020.12.18-ний өдрийн 2/17 дугаар тогтоолоор нийт 2,462,537.0 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Хүснэгт №14. Төсвийн төлөвлөлт байгууллагаар /мянган төгрөг/

| Орлогын төрөл | Төсвийн төсөл | Анх батлагдсан төсөв | Зөрүү |
|------------------------------|--------------------|----------------------|-------------------|
| Иргэдийн төлөөлөгчдийн хурал | 76,436.7 | 80,036.7 | -3,600.0 |
| Засаг даргын Тамгын газар | 387,348.8 | 388,348.8 | -1,000.0 |
| Сургууль | 606,854.4 | 770,823.2 | -163,968.8 |
| Цэцэрлэг | 211,352.2 | 297,643.4 | -86,291.2 |
| Эрүүл мэндийн төв | 533,621.2 | 533,621.2 | 0.0 |
| Соёлын төв | 113,429.1 | 115,923.5 | -2,494.4 |
| Сум хөгжүүлэх сан | | 63,500.0 | -63,500.0 |
| Орон нутгийн хөгжлийн сан | | 212,640.2 | -212,640.2 |
| Нийт дүн | 1,929,042.4 | 2,462,537.0 | -533,494.6 |

Эх сурвалж: Баацагаан сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2020.12.18-ний өдрийн 2/17 дугаар тогтоолоор анх 2,462,537.0 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2021.07.26-ний өдрийн 3/21 дугаар тогтоолоор 111,546.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан бол тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зардлыг 2021.12.06-ний өдрийн А/742 дугаар захирамжаар 574.0 мянган төгрөгөөр бууруулснаар сумын нийт төсөв 2,573,509.9 мянган төгрөг болсон бөгөөд сумын ИТХ-ын хуралдаанаар төсвийг нэмж батлаагүй байна.

Нийт зардлын 1,405,550.5 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 176,344.0 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 708,704.4 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 72,100.0 мянган төгрөгийг сумын орон нутгийн төсвөөс, 4,494.4 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 33,571.4 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс, сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн орлогыг 63,500.0 мянга, 18,025.0 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, ОНХС-аас олгосон малжуулах, өвсний эргэн төлөлтийн орлогоор 62,271.2 мянга, сумын төсвийн урьд оны үлдэгдлээс 28,949.0 мянган тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээр 1,359,226.2 мянга, орон нутгийн төсвөөс авах санхүүжилтээр 792,590.2 мянга, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээр 176,344.0 мянга, туслах үйл ажиллагааны орлогоор 536.0 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоор 131,589.4 мянга, Эрүүл мэндийн даатгалын сангаас 28,658.6 мянган төгрөгийг санхүүжилт авч улсын төсөвт 46,324.4 мянга, орон нутгийн төсөвт 11,098.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №15. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/

| Байгууллагын нэр | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь | Улсын төсөвт төвлөрүүлсэн | ОН төсөвт төвлөрүүлсэн |
|------------------|------------|-----------|-------|------|---------------------------|------------------------|
| | | | | | | |

Баацагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | | |
|-----------------|--------------------|--------------------|------------------|-------------|-----------------|-----------------|
| ИТХ | 84,536.7 | 82,618.6 | 1,157.3 | 97.7 | | 1918.0 |
| ЗДТГ | 441,447.1 | 431,299.4 | 187.1 | 97.7 | | 9179.9 |
| Сургууль | 807,071.4 | 781,184.9 | 4,001.0 | 96.8 | 24,588.3 | |
| Цэцэрлэг | 280,612.6 | 263,507.3 | 19,441.6 | 93.9 | 15,168.7 | |
| Соёлын төв | 115,080.7 | 112,886.0 | 5,705.0 | 98.1 | | 0.3 |
| Хүн эмнэлэг | 533,621.2 | 519,311.0 | 18.3 | 97.3 | 6,567.4 | |
| СХСан | 63,500.0 | 541.1 | 16,407.2 | 0.9 | | |
| ОНХСан | 247,640.2 | 140,607.9 | 70,878.0 | 56.8 | | |
| Нийт дүн | 2,573,509.9 | 2,331,956.2 | 117,795.6 | 90.6 | 46,324.4 | 11,098.2 |

Эх сурвалж: Баацагаан сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл мянган төгрөг буюу 90.6 хувьтай байгаа нь Ерөнхий боловсролын сургуулийн урсгал зардлыг 24,588.3 мянга, Цэцэрлэгийн зардлыг 15,168.7 мянга, ЭМТ-ийн зардлыг 6,567.4 мянга, ИТХ-ын зардлыг 1,918.0 мянга, ЗДТГ-ын зардлыг 9,179.9 мянга, Соёлын төвийн зардлыг 0.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 94,033.7 мянга, ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 6,194.0 мянга, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 2,110.0 мянга, эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлогоос 165,789.3 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 191,845.7 мянга, Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 44,501.9 мянга, хөрөнгийн зардалд 2,000.0 мянга, Хөдөө орон нагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 29,589.4 мянган төгрөгийг зарцуулж 190.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 16. Нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | ИТХ | ЗДТГ | ЕБС | Цэцэрлэг | ЭМТ | НИЙТ |
|---|---------|----------|----------|----------|-----------|-----------|
| НИЙТ ОРЛОГО | 1,000.0 | 22,577.0 | 29,022.6 | 49,738.1 | 165,789.3 | 268,127.0 |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,000.0 | 14,273.0 | 29,022.6 | 49,738.1 | | 94,033.7 |
| ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 6,194.0 | | | | 6,194.0 |

Аудитын код: БНА-2021/13/СТА-ТТЗ

Баацагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | | |
|---|----------------|-----------------|-----------------|-----------------|------------------|------------------|
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 2,110.0 | | | 0.0 | 2,110.0 |
| Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого | | | | | 165,789.3 | 165,789.3 |
| НИЙТ ЗАРЛАГА | 1,000.0 | 22,567.0 | 29,022.6 | 49,558.1 | 165,789.3 | 267,937.0 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,000.0 | 22,567.0 | 4,489.4 | | 163,789.3 | 191,845.7 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | | 0.0 | 44,501.9 | | 44,501.9 |
| Хөрөнгийн зардал | | | | | 2,000.0 | 2,000.0 |
| Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | | 24,533.2 | 5,056.2 | | 29,589.4 |
| Төсөвт төвлөрүүлсэн | 0.0 | 10.0 | 0.0 | 180.0 | 0.0 | 190.0 |

Эх сурвалж: Баацагаан сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд сумын Засаг даргын нөөц санг 39,600.0 төгрөгөөр тодотгон баталж 39,551.4 төгрөгийг зарцуулж үлдэгдэл 48.5 мянган төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогод төвлөрүүлсэн.

Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын дагуу авч үзвэл: Нийт зарцуулалтын 66.7 хувийг буюу 26,414.4 төгрөгийг 2.1.1 дэх заалтын хүрээнд хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, цөлжилт, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх зардалд, 10.2 хувь буюу 4,057.0 төгрөгийг 2.1.5 дахь заалтын хүрээнд Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээнд, 23.1 хувь буюу 9,080.0 төгрөгийг 2.1.6 дахь заалтын хүрээнд шагнал, урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж дэмжлэгт тус тус зарцуулжээ.

3.8 Аудитын гол асуудал

Сумын Засаг дарга нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 8 үндсэн зорилтын хүрээнд 66 арга хэмжээний хэрэгжилтийг 99.4 хувийн гүйцэтгэлтэй тайлагнажээ.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 2,573,509.9 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 2,331,956.2 мянган төгрөгийг зарцуулж, 90.6 хувийн биелэлттэй байна.

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 7,461.5 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл иргэний орлого тодорхойлох хуудсаар тодорхойлсон татварын орлого 4,473.0 мянга, бууны татвар 94.0 мянга, хадгаламжийн

Аудитын код: БНА-2021/13/СТА-ТТЗ



хүүгийн орлого 420.9 мянга, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлого 6,295.6 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

Харин улсын тэмдэгтийн хураамж 22.0, хувь буюу 329.7 мянга, газрын төлбөр 31.5 хувь буюу 409.8 мянга, хог хаягдлын үйлчилгээний хураамж 38.8 хувь буюу 2,327.5 мянга, түгээмэл тархацтай АМАТ 37.5 хувь буюу 375.0 мянга, хүү торгуулийн орлого 3.5 хувь буюу 380.0 мянган төгрөгөөр орлого тус тус тасарсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогод Засаг даргын Тамгын газар 2000.0 мянга, Соёлын төв 2,494.4 мянга, нийт 4,494.4 мянган төгрөгийн орлогыг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 836.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж орлогын төлөвлөгөө 81.4 хувиар буюу 3,658.4 мянган төгрөгөөр тасарсан байна.

Сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн төлөлтөөр тайлант онд 63,500.0 мянган төгрөгийг оруулахаар баталснаас 81,727.8 мянган төгрөгийн орлогыг оруулсан байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Заг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас Заг сумын Засаг даргын харьяа байгууллагад аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт №17. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн

| Байгууллагын нэр | Байгууллагын тоо | | | | Аудитын санал дүгнэлтийн төрөл | | | | |
|-------------------|------------------|------------|---------------------------|--------------------|--------------------------------|-----------|----------------|----------|----------------------------------|
| | Хамрагдвал зохих | Хамрагдсан | Гүйцэтгэсэн | | Бүгд | Үүнээс | | | |
| | | | Бие дааж дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| ЕБСургууль | 1 | 1 | 1 | | 1 | 1 | | | |
| Хүүхдийн цэцэрлэг | 1 | 1 | 1 | | 1 | 1 | | | |
| ЗДТГ | 1 | 1 | 1 | | 1 | 1 | | | |
| ИТХурал | 1 | 1 | | 1 | | | | | |
| Соёлын төв | 1 | 1 | | 1 | | | | | |
| ЭМТ | 1 | 1 | 1 | | 1 | 1 | | | |
| ОНХС | 1 | 1 | | 1 | | | | | |
| СХС | 1 | 1 | | 1 | | | | | |
| НИЙТ ДҮН | 8 | 8 | 4 | 4 | 4 | 4 | 0 | 0 | 0 |

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллагыг түүвэрт хамруулсан ба аудитад хамрагдсан байгууллагуудад зөрчилгүй санал дүгнэлтийг өгсөн байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 325,425.0 мянган төгрөгийн 14 алдаа, зөрчил илэрснээс 7,888.9 мянган төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд залруулж, 517.3 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 79,886.5 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэн, 237,132.3 мянган төгрөгийн 9 зөрчилд зөвлөмж өгч ажилласан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №18. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн

| | |
|--|---|
| | Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт |
|--|---|

Баацагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| Байгууллагын нэр | Нийт алдаа зөрчлийн дүн | | Залруулга | | Тогтоосон төлбөрийн акт | | Өгсөн албан шаардлага | | Өгсөн зөвлөмж | |
|---|-------------------------|-----------|-----------|---------|-------------------------|-------|-----------------------|----------|---------------|-----------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн зөрчил | | | | | | | | | | |
| ЕБСургууль | 2.0 | 3,161.9 | - | - | 1.0 | 369.9 | | | 1.0 | 2,792.0 |
| ЗДТГ | 1.0 | 14,107.5 | | | - | - | | | 1.0 | 14,107.5 |
| ЭМТ | 3.0 | 13,262.8 | 1.0 | 7,888.9 | 1.0 | 147.4 | - | - | 1.0 | 5,226.5 |
| СТА зөрчлийн дүн | 6.0 | 30,532.2 | 1.0 | 7,888.9 | 2.0 | 517.3 | - | - | 3.0 | 22,126.0 |
| СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | |
| ЕБСургууль | 2.0 | 207,054.4 | | | | | | | 2.0 | 207,054.4 |
| Хүүхдийн цэцэрлэг | 2.0 | 68,499.4 | | | | | 1.0 | 65,891.5 | 1.0 | 2,607.9 |
| ЗДТГ | 2.0 | 13,995.0 | | | | | 1.0 | 13,995.0 | 1.0 | - |
| ОНХСан | 1.0 | 5,344.0 | | | | | | | 1.0 | 5,344.0 |
| ЭМТ | 1.0 | - | | | | | | | 1.0 | |
| Нийцлийн аудитын дүн | 8.0 | 294,892.8 | - | - | - | - | 2.0 | 79,886.5 | 6.0 | 215,006.3 |
| Нийт дүн | 14.0 | 325,425.0 | 1.0 | 7,888.9 | 2.0 | 517.3 | 2.0 | 79,886.5 | 9.0 | 237,132.3 |

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаа зөрчлийг санхүүгийн тайлангийн болон нийцлийн аудиттай холбоотой асуудал гэж ангилан үзсэн бөгөөд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 22,786.3 мянган төгрөгийн 13 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 185,113.1 мянган төгрөгийн 5 зөрчил тус тус илэрсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны сайтад оруулбал зохих мэдээллээс 5344.0 мянган төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Хүснэгт 19. Шилэн дансны мэдээлэл

Аудитын код: БНА-2021/13/СТА-ТТЗ

| д/д | хугацаа | төрөл | удаа | хугацаанд нь мэдээлсэн | хугацаа хоцроосон | мэдээлээгүй |
|-------------|------------|-------|------|------------------------|-------------------|-------------|
| 1 | Бүтэн жил | 12 | 12 | 12 | 0 | |
| 2 | Хагас жил | 3 | 3 | 3 | 0 | |
| 3 | Улирал бүр | 2 | 8 | 8 | 0 | |
| 4 | Сар бүр | 5 | 60 | 60 | 0 | |
| 5 | Тухай бүр | 6 | 72 | 70 | 2 | |
| Нийт | | 28 | 155 | 153 | 2 | 0 |

Эх сурвалж. Баацагаан сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудас

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулах.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Уг тогтоолын хэрэгжилтийг Баацагаан сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Баацагаан сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 оны 12 дугаар сард 13,995.0 мянган төгрөгийн төсвийн хөрөнгөөр албан тасалгааны зориулалттай ширээ, сандал, буйдан, хөшиг зэрэг тавилга эд хогшил худалдан авсан байна.
- Ерөнхий боловсролын сургууль нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 120,193.0 мянган төгрөг батлагдсан ба нийт батлагдсан төсвийн 20 хувь нь 24,038.6 мянган төгрөг байна. Тус онд 1,298.1 мянган төгрөгийн хэмнэлт үүссэн бөгөөд 22,740.5 мянган төгрөгийн хэмнэлтийг үүсгээгүй байна.
- Цэцэрлэг нь тогтмол зардлыг 2,607.9 мянган төгрөгөөр хэмнэж ажиллаагүй зэрэг нь “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 2-р сарын 17-ны 43 дугаар тогтоолын 1.1, “1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах” гэсэн заалтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Иймд дээрх зөрчилд ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар Засгийн газрын 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг сумын Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 1/63 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна. Хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 20 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Аудитын код: БНА-2021/13/СТА-ТТЗ

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Биелэгдээгүй | | Хэрэгжилтийн хувь Хувь |
|----------|---------------------|-----|---------|-----|--------------|-----|---------------------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | |
| Зөвлөмж | 2 | | 2 | | | | 100.0 |
| Нийт | 2 | | 2 | | | | 100.0 |

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүйн Харин тайлант хугацаанд ЭМД-аас авах санхүүжилтийн 177,443.0 мянган төгрөгийн авлага үүссэн ба цаашид авлагын тооцоог тухайн онд багтаан шийдвэрлэхэд анхаарч ажиллах шаардлагатай ба авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан.

Цаашид Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8."төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заалтыг хэрэгжүүлж ажиллах.

4. Аудитын илрүүлэлт

Баацагаан сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар алдаа зөрчил давтан гаргахгүй байх 25,918.0 мянган төгрөгийн 4 зөвлөмжийг хүргүүлж байна.

4.2.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТАЙЛАГНАЛТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Илрүүлэлт: Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайлан ирүүлэхдээ төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасан бүрэлдэхүүн хэсгээр ирүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын ИТХ-аар төсвийг хөтөлбөр, арга хэмжээ, хүрэх үр дүнгийн зорилттой уялдуулан батлуулж жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасан бүрэлдэхүүн хэсгээр гаргаж тайлбар танилцуулгын хамт ирүүлж байх.

2. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

Илрүүлэлт: Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх хэсэгт "Дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон" гэсэн заалтын дагуу аймгийн Засаг даргын 2021.12.06-ны өдрийн А/742 дугаартай захирамжаар сумын Сургуулийн төсөв 10,000.0 мянган төгрөг нэмэгдэж, Цэцэрлэгийн төсөв 10,574.0 мянган төгрөгөөр буурсан байхад төсөвт тодотгол хийгээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын Засаг дарга дээд шатны төсөв захирагчаас төсөвт өөрчлөлт оруулсан тохиолдолд төсвийн тодотголыг боловсруулж тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хуралд өргөн мэдүүлж төсөвт тодотгол оруулж байх.

3. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

Илрүүлэлт: Тухайн сумын Төсвийн Ерөнхийлөн захирагчийн харьяаны төсөвт байгууллагууд нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 325,425.0 мянган төгрөгийн

14 алдаа зөрчил илэрсэн нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллагуудад дотоод хэрэгжүүлж ажиллаагүй байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасныг зөрчсөн “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Засаг дарга өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсөвт байгууллагуудад дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах

4.УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

Илрүүлэлт: Тайлант хугацаанд шилэн дансны сайтад оруулбал зохих мэдээллээс 5344.0 мянган төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчмыг баримтална” гэснийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 09 дүгээр сарын 05 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

| Д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|--|-------------------------------------|----------------------|----------|-----------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|----------|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| | Баацагаан сумын ТТЗ | 3 | 20,574.0 | | | | | | | 3 | 20,574.0 |
| | Дүн | 3 | 20,574.0 | | | | | | | 3 | 20,574.0 |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| | Шилэн дансны хэрэгжилт | 1 | | | | | | | | 1 | 5,344.0 |
| | Дүн | 1 | | | | | | | | 1 | 5,344.0 |
| | Нийт дүн | 4 | 25,918.0 | | | | | | | 4 | 25,918.0 |

Хавсралт 1. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Бэлтгэх 1. Баацагаан сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангаар

| | | | |
|------------|--------------|---|---------------------|
| Огноо | Аудитын нэр: | Баацагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит | Аудитын код: |
| 2022.03.25 | | | БНА-2022/13/СТА-ТТЗ |

Баацагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | |
|------------------------------|-----------------------------|---------------|
| Шалгагдсан байгууллагын нэр: | Баацагаан сумын Засаг дарга | Мянган төгрөг |
|------------------------------|-----------------------------|---------------|

| Д/д | Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн /мянган төгрөг/ | Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|-------------|---|----------------------------|-----------------------------|---|-----------------------|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| А | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| Засаг дарга | | 25,918.0 | | | |
| 1 | Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайлан ирүүлэхдээ төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасан бүрэлдэхүүн хэсгээр ирүүлээгүй байна. | 0.0 | Зөвлөмж өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | С.Энхтөр, А.Гэрэлмөнх |
| 2 | Тайлант хугацаанд шилэн дансны сайтад оруулбал зохих мэдээллээс 5344.0 мянган төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. | 5,344.0 | Зөвлөмж өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | С.Энхтөр, А.Гэрэлмөнх |
| 3 | Тухайн сумын Төсвийн Ерөнхийлөн захирагчийн харьяаны төсөвт байгууллагууд нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 325,425.0 мянган төгрөгийн 14 алдаа зөрчил илэрсэн нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллагуудад дотоод хэрэгжүүлж ажиллаагүй байна | 0.0 | Зөвлөмж өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | С.Энхтөр, А.Гэрэлмөнх |
| 4 | Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх хэсэгт “Дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон” гэсэн заалтын дагуу аймгийн Засаг даргын 2021.12.06-ны өдрийн А/742 дугаартай захирамжаар сумын Сургуулийн төсөв 10,000.0 мянган төгрөг нэмэгдэж, Цэцэрлэгийн төсөв 10,574.0 мянган төгрөгөөр буурсан байхад төсөвт тодотгол хийгээгүй байна. | 20,574.0 | Зөвлөмж өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | С.Энхтөр, А.Гэрэлмөнх |

2. Баацагаан сумын төсөвт байгууллагын санхүүгийн тайлангаар

| Д/д | Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн /мянган төгрөг/ | Алдаа, зөрчлийн шийдвэрлэл т. | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|-------------------------------------|---|-------------------------------------|--|--|--------------------------|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| А | 2 | 2 | 4 | 5 | 6 |
| Сумын нийт дүн | | 325,425.0 | | | |
| Засаг даргын Тамгын газар | | 28,102.5 | | | |
| 1 | Өглөг авлагын тооцоог татварын худалдан авалтын тайлантай тулган шалгахад “Хонгор Ойл” ХХК-аас 1,807.5 мянган төгрөг, “Батцоож хийц” ХХК-аас 9,800.0 мянган төгрөг, Хувь хүний хөгжлийн алсын хараа институт 2,500,0 мянган төгрөгийн төлбөрийн баримтыг системд шивээгүй байсныг аудитын явцад 2022 оны 02 дугаар сард нөхөн бүртгүүлэв. | 14,107.5 | Зөвлөмж өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Б.Наранбаатар, Д.Анхтуяа |
| 2 | Тухайн ЗДТГ нь 2021 оны 12 дугаар сард 13,995.0 мянган төгрөгийн төсвийн хөрөнгөөр албан тасалгааны зориулалттай ширээ, сандал, буйдан, хөшиг зэрэг тавилга эд хогшил худалдан авсан байна. | 13,995.0 | Албан шаардлага өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Б.Наранбаатар, Д.Анхтуяа |
| 3 | Тус байгууллага нь Шилэн дансны цахим сайтад байршуулах "... гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр"-тэй холбоотой 2 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн | - | Зөвлөмж өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Б.Наранбаатар, Д.Анхтуяа |
| Ерөнхий боловсролын сургууль | | 210,216.3 | | | |
| 4 | Бага ангийн багш Б.Өлзиймаагийн 6-р сард бодогдсон 1,541.5 мянган төгрөгийн амралтын мөнгөнийг НДХ-т 6-р сард мэдээлсэн бөгөөд тус цалинг 07-дугаар сард давхардуулан мэдээлж, 369,9 мянган төгрөгийг илүү төлсөн | 369.9 | Төлбөрийн акт тогтоосон | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Г.Насанбаяр, Г.Батдалай |
| 5 | Мөнгөн хөрөнгийн 25 харилцагчтай холбоотой 204,765.0 мянган төгрөгийн худалдан авалтын гүйлгээг татварын цахим системд бүртгэгдсэн төлбөрийн баримттай тулгахад 4 харилцагчтай холбоотой 2,792.0 мянган төгрөгийн төлбөрийн цахим баримтыг харилцагчаас гаргуулан аваагүй байна | 2,792.0 | Зөвлөмж өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Г.Насанбаяр, Г.Батдалай |

Баацагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | |
|----------------------------------|--|-----------------|---------------------------------|----------------------------------|----------------------------|
| 6 | Тайлант онд тогтмол зардалд 120,193.0 мянган төгрөг батлагдсан ба нийт батлагдсан төсвийн 20 хувь нь 24,038.6 мянган төгрөг байна. Тус онд 1,298.1 мянган төгрөгийн хэмнэлт үүссэн бөгөөд 22,740.5 мянган төгрөгийн хэмнэлтийг үүсгээгүй байна. | 22,740.5 | Зөвлөмж өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Г.Насанбаяр, Г.Батдалай |
| 7 | Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл мэдээлбэл зохих 149 мэдээллээс 184,313.9 мянган төгрөгийн 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. | 184,313.9 | Зөвлөмж өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Г.Насанбаяр, Г.Батдалай |
| Орон нутгийн хөгжлийн сан | | 5,344.0 | | | |
| 8 | Шилэн дансны тухай хуулийн 6.4.4 т заасан 5344000 мянган төгрөгийн 1 мэдээллийг хоцроосон | 5,344.0 | Зөвлөмж өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | С.Энхтөр, А.Нарангэрэл |
| Эрүүл мэндийн төв | | 13,262.8 | | | |
| 9 | Тайлант онд НДШ-д кодын өөрчлөлтөөр тухайн байгууллагад илүү төлсөн шимтгэлийг суутган тооцож аваагүй 147.4 мянган төгрөгийг төсвөөс илүү төлж авлага үүсгэсэн байна. | 147.4 | Төлбөрийн акт | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Д.Болормаа, Н.Үүрцайх |
| 10 | Шилэн дансны цахим системд нийт төрлийн 519,310.9 мянган төгрөгийн 119 мэдээллийг хуулийн хугацаанд ил тод мэдээлхээс 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн | - | Зөвлөмж өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Д.Болормаа, Н.Үүрцайх |
| 11 | Хайрхан фарм ХХК нь 2019 онд аймгийн ИТХ-ын тогтоолоор татан буугдсан ба тус байгууллагатай холбоотой өглөг, авлагыг барагдуулсан тул 2018 онд үүссэн Хайрхан фарм ХХК-ийн 7,303,9 мянган төгрөгийг өглөг, сумын Эргэлтийн эмийн сантай холбоотой 585.0 мянган төгрөгийн авлагыг хааж санхүүгийн тайлан залруулав. | 7,888.9 | Санхүүгийн тайлангийн залруулга | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Д.Болормаа, Н.Үүрцайх |
| 12 | 2018 онд үүссэн эмийн тооцооны авлага 5226.5 мянган төгрөг байхад авлагыг барагдуулаагүй, тус авлагаас нь 4,641.4 мянга төгрөгийн авлага нь аймгийн ЭМГ-аас эмийн авлага, 585.0 мянган төгрөгийн авлага нь сумын Эргэлтийн эмийн сангийн эмийн санч Тогосмаатай холбоотой байна. | 5,226.5 | Зөвлөмж өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Д.Болормаа, Н.Үүрцайх |

Баацагаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| Хүүхдийн цэцэрлэг | | 68,499.4 | | | |
|-------------------|--|----------|-----------------------|----------------------------------|-----------------------|
| 13 | Тогтмол зардлыг 2,607.9 мянган төгрөгөөр хэмнэж ажиллаагүй байгаа нь "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 2021 оны 2-р сарын 17-ны 43 дугаар тогтоолын "1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах" гэсэн заалтай нийцэхгүй байна. | 2,607.9 | Зөвлөмж өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Ч.Энхтуяа, Г.Батдалай |
| 14 | Шилэн дансны цахим системд нийт 334,023.5 мянган төгрөгийн 119 мэдээллийг хуулийн хугацаанд ил тод мэдээлэхээс 65,891.5 мянган төгрөгийн 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна. | 65,891.5 | Албан шаардлага өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Ч.Энхтуяа, Г.Батдалай |

оОо